

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн 2016 оны
санхүүгийн үйл ажиллагаа



***Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд
дотоод хяналт хийгдээгүйгээс ихээхэн хэмжээний санхүүгийн зөрчил
оршиж байна.***

Сүхбаатар сум 2017 оны 09 сар

Тайланг бэлтгэсэн:

**Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын
газар**

Дарга, Тэргүүлэх аудитор

Ч.Энхтуяа

Аудитын менежер

Б.Батмөнх

Ахлах аудитор

С.Баасансүрэн

Аудитор

Ц.Уртнасан

2017 оны 09 дүгээр сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70362442 дугаарын утсаар
холбоо барина уу.

ХАЯГ:

Сэлэнгэ аймаг
Сүхбаатар хот
Аймгийн ЗДТГ-ын
өргөтгөлийн 2-р давхар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4
Үндсэн мэдээлэл.....5
Аудитын дүн.....6-15

Бүлэг 1. Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжиж байна уу.

1.1. Сумдын ЭМТ-ийн эмийн сан нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна уу.

1.2. Сумдын ЭМТ-ийн эмийн сан нь ард иргэдийг зайлшгүй шаардлагатай эмээр ханган үйлчлэх зорилго, зорилтоо гүйцэтгэж байгаа эсэх.

1.3. Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу?

Бүлэг 2. Сумдын ЭМТ-ийн эмийн сан нь орлогыг бүрэн төвлөрүүлж, холбогдох хууль журмын хүрээнд зарцуулж байна уу.

2.1. ЭМТ-үүд нь эмийн сангийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх.

2.2. ЭМТ-үүд нь төвлөрүүлсэн эмийн орлогыг хууль, журмын дагуу зарцуулсан байна уу?

2.3. Хөрөнгийг НББ-д үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэх.

Илрүүлсэн зөрчил

Дүгнэлт.....

Зөвлөмж.....

Холбогдох байгууллагын санал:

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

ЭА	Эрсдэлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
АДБОУС	Аудитын Дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
МУ	Монгол Улс
НББ	Нягтлан бодох бүртгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.Аудитын нэр:

Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа

2.Аудитын код:

СЭА-2017/02/СТА-ЭА

3.Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

4.Аудитын зорилт:

Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн 2016 оны удирдлага, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлтэй асуудлыг хамруулан шалгаж, дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад эрсдэлийн аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
- Сумдын ЭМТ-ийн эмийн сан нь орлогыг бүрэн төвлөрүүлж, холбогдох хууль журмын хүрээнд зарцуулж байна уу?

5.Аудитын хамрах хүрээ:

Аудитад сумдын ЭМТ-ийн эмийн сангийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээ, тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтууд, холбогдох бусад баримт материал, мэдээллийн эх сурвалжуудыг хамруулан шалгалаа.

6.Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС-3000-3001/-ийг ашиглан сумдын эрүүл мэндийн төвүүдийн дарга, нягтлан бодогч, эм баригч нартай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, тус байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, нотлох зүйлийг ашиглан түүнд судалгаа, шинжилгээ хийх, давтан шалгах зэрэг арга зүйг ашиглалаа.

7.Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ц.Уртнасан нар 2017 оны 09 дүгээр сарын 06-наас 10 дугаар сарын 17-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

8. Үндсэн мэдээлэл

Анх 2006 онд Япон улсын тусламжийн “Хамт олон-Эрүүл мэнд” төслийн хүрээнд нэг жилийн хэрэгцээний эмийг үнэ төлбөргүй олгох замаар аймгийн хэмжээнд эргэлтийн эмийн сангийн тогтолцоог бүрдүүлснээр 2015 он хүртэл уг тогтолцоогоор үйл ажиллагаа явуулж иржээ.

Эрүүл мэнд спортын яамны 2015 оны 1а/2642 дугаар албан бичиг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 105 дугаар тогтоолын 1 дэх “Эргэлтийн эмийн сангууд болон тэдгээрийн ажилтнуудыг тухайн сум, тосгодын эрүүл мэндийн төвүүдийн харьяалалд бүтэц, орон тоонд нь багтаан шилжүүлсүгэй” гэсэн заалтыг үндэслэн аймгийн ЭМГ-ын даргын тушаалаар ЭЭС-гуудыг сумдын Эрүүл мэндийн төвд шилжүүлэх ажлын хэсгийг байгуулсан байна. Ажлын хэсэг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байсан 15, мэргэжлийн хүнгүйгээс үйл ажиллагаагаа явуулаагүй 5 зэрэг нийт 20 эмийн эргэлтийн сангуудын 41335.2 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 35755.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг сумдын ЭМТ-д шилжүүлэн өгсөн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Д/д	Эргэлтийн эмийн сангийн нэрс	Эргэлтийн хөрөнгө		Үндсэн хөрөнгийн үнийн дүн /мян.төг/
		Нэр төрөл	Үнийн дүн /мян.төг/	
1	Алтанбулаг ЭЭС	194	3490.4	1937.0
2	Баруунбүрэн ЭЭС	263	2843.0	1320.0
3	Бугант ЭЭС	72	2276.1	74.1
4	Баянгол ЭЭС	318	4985.8	7027.7
5	Дулаанхаан ЭЭС	51	405.9	
6	Ерөө ЭЭС	166	2130.8	2580.0
7	Жавхлант ЭЭС			
8	Зүүнбүрэн ЭЭС	272	1612.9	
9	Номгон ЭЭС	233	2104.8	1885.0
10	Орхон ЭЭС	218	2314.2	700.0
11	Орхонтуул ЭЭС	303	5249.5	5444.3
12	Рашаант ЭЭС	22	2075.6	1662.8
13	Сант ЭЭС			
14	Түшиг ЭЭС	179	2062.6	1127.9
15	Түнхэл ЭЭС	51	746.8	2458.7
16	Хушаат ЭЭС	294	3095.4	2975.9
17	Хэрх ЭЭС	58	708.9	790.0
18	Хүдэр ЭЭС	138	2617.7	2908.0
19	Цагааннуур ЭЭС	8	102.2	1414.0
20	Шаамар ЭЭС	177	2512.6	1450.0
	Нийт дүн		41335.2	35755.4

Ерөө, Хүдэр, Шаамар сумд, Бугант тосгоны ЭМТ-ийн эмийн сангууд нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлээгүй, эмийн тайлан, мэдээ огт гаргаж байгаагүйн улмаас аудитын явцад эмийн тайланг нөхөж хийлгүүлэхэд цаг хугацаа их шаардаж, аудитад хүндрэл учруулж байсан бөгөөд Түшиг сумын ЭМТ-ийн

эмийн сангийн сүүлийн хагас жилийн санхүүгийн баримтууд алга болсон гэсэн шалтгаанаар аудитад хамрагдаагүй болно.

БҮЛЭГ 1

Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжиж байна уу.

Сумдын ЭМТ-ийн эмийн сангууд нь ард иргэдийг зайлшгүй шаардлагатай эмээр ханган үйлчлэх зорилго, зорилтоо бүрэн хэрэгжүүлээгүй, үйл ажиллагаа нь урсгалаараа явж ирсэн байна.

1.1. Сумдын ЭМТ-ийн эмийн сан нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна уу.

Зарим сумдын ЭМТ-үүд нь эмийн сангийн тусгай зөвшөөрлийг сунгуулалгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрүүл мэнд, спортын яамны 2015 оны 1а/2642 дугаар албан бичиг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 105 дугаар тогтоолын 1 дэх “Эргэлтийн эмийн сангууд болон тэдгээрийн ажилтнуудыг тухайн сум, тосгодын эрүүл мэндийн төвүүдийн харьяалалд бүтэц, орон тоонд нь багтаан шилжүүлсүгэй” гэсэн заалтыг үндэслэн аймгийн ЭМГ-ын даргын тушаалаар сумдын ЭЭС-гуудыг Эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлж өгөх ажлын хэсгийг байгуулсан байна. Уг ажлын хэсэг нь 2015 оны 11-р сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 04-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байсан 20 эмийн эргэлтийн сангийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг сумдын ЭМТ-ийн харьяалалд шилжүүлэн өгсөн байна.

Сумын ЭМТ-ийн дарга нарын тушаалаар ЭЭС-гуудын эм баригч нарыг орон тооны ажилтнаар томилсон бөгөөд ажилд томилсон тушаал, 2016 онд олгосон цалинг /Хавсралт №1/-д дэлгэрэнгүй харуулав.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1¹, 8 дугаар зүйлийн 8.1² дэх заалтуудад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх “Тусгай зөвшөөрөл” болон “Эм барих эрхийн зөвшөөрөл”-ийн дагуу сумдын ЭМТ-ийн эмийн сан үйл ажиллагаагаа явуулахаар хуульчилсан байдаг.

Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн тусгай болон эм барих эрхийн зөвшөөрлүүдийг дараах хүснэгтээр харуулбал:

№	Сумын нэр	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар	Хугацаа дуусах огноо	Эм барих эрхийн зөвшөөрлийн дугаар	Хугацаа дуусах огноо
1	Алтанбулаг	ЭСХ-15/16/196	2020.02.06	0002544	2021.06.09
2	Баруунбүрэн	ЭСХ-15/16/180	2017.08.15	0002684	2020.01.30
3	Зүүнбүрэн	ЭСХ-15/16/183	2017.02.06	0002653	2019.12.18

¹ Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн утгвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

² ЭМ-ийн тухай хуулийн 22.3-т заасан зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн эм барих үйл ажиллагаа эрхэлнэ.

4	Жавхлант	ЭСУ-16/16/246	2017.11.11	0003671	2021.09.02
5	Орхон	ЭС-15/16/184	2018.02.06	0003361	2021.06.09
6	Сант	ЭУ-14/16/159	2019.06.17	0002433	2019.07.31
7	Номгон	ЭС-15/16/181	2017.08.15	0003355	2021.06.09
8	Хушаат	ЭС-15/16/186	2018.02.06	0003367	2021.06.09
9	Цагааннуур	ЭС-16/16/236	2017.04.14	0002656	2019.12.18
10	Түшиг	ЭСХ-15/16/125	2017.08.06	0003104	2020.07.20
11	Баянгол	ЭСХ-15/16/197	2017.02.06	0002129	2018.07.30
12	Ерөө	ЭСХ-15/16/207	2018.02.06	0004113	2022.07.16
13	Бугант	160018	2014.06.17	0003613	2021.07.20
14	Шаамар	ЭС-16/16/237	2019.04.14	0002281	2020.08.04
15	Дулаанхаан	ЭС-17/16/259	2018.08.08	0002442	2019.07.31
16	Орхонтуул	ЭСХ-15/16/209	2018.02.06	0002529	2019.08.05
17	Рашаант	ЭС-16/16/235	2017.04.14	0002281	2020.12.15
18	Хүдэр	ЭСХ-15/16/210	2018.02.06	0010391	Хугацаагүй
19	Түнхэл	ЭСХ-15/16/208	2018.02.06	0002932	2020.07.17
20	Хэрх	160116	2015.02.06	0007181	2022.07.14

Хүснэгтээс үзэхэд Алтанбулаг, Жавхлант, Орхон, Сант, Хушаат, Ерөө, Шаамар, Орхонтуул, Хүдэр сумд, Дулаанхаан, Түнхэл тосгодын ЭМТ-ийн эмийн сангийн “Тусгай зөвшөөрөл” болон бүх сумдын эм баригч нарын “Эм барих эрхийн гэрчилгээ”-ний хугацаа хүчинтэй байгаа тул эрүүл мэндийн чиглэлээр хууль эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Харин Баруунбүрэн, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Баянгол сумд, Бугант, Номгон, Рашаант, Хэрх тосгодын ЭМТ-ийн эмийн сангуудын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч, өнөөдрийг хүртэл сунгалт хийлгэлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8³ дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд дээрх сумдын ЭМТ-үүд эмийн сангийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулж, хууль эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай байна.

1.2. Сумдын ЭМТ-ийн эмийн сан нь ард иргэдийг зайлшгүй шаардлагатай эмээр ханган үйлчлэх зорилго, зорилтоо гүйцэтгэж байгаа эсэх.

Эмийн сангуудын 90 хувь нь ард иргэдийг зайлшгүй шаардлагатай эмийн төрлөөр ханган үйлчлэх, зорилго, зорилтоо бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 215 дугаар тушаалаар зайлшгүй шаардлагатай эмийн 7 дахь жагсаалтын 1 дүгээр хавсралтад сум, тосгодын эмийн сангуудын иргэдэд үйлчлэх зайлшгүй шаардлагатай 29 бүлгийн 271 нэр төрлийн эмийг баталсан байна.

Тайлант онд зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтын дагуу сумдын ЭМТ-ийн эмийн сангийн иргэдэд үйлчилсэн эмийн төрлийг дараах хүснэгтээр харуулбал:

³ Тусгай зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтээ тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө тавьж шийдвэрлүүлнэ.
СУМДЫН ЭМТ-ИЙН ЭМИЙН САНГИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

№	Сумын нэр	Зайлшгүй шаардлагатай эмийн төрөл	Сумдын ЭМТ-ийн эмийн санд байгаа зайлшгүй шаардлагатай эмийн төрөл	Эзлэх хувь
1	Алтанбулаг	271	167	61.6
2	Баруунбүрэн	271	268	98.9
3	Зүүнбүрэн	271	264	97.4
4	Орхон	271	199	73.4
5	Номгон	271	244	90.0
6	Хушаат	271	260	95.9
7	Түшиг	271	254	93.7
8	Баянгол	271	271	100
9	Дулаанхаан	271	81	30.0
10	Ерөө	271	176	64.9
11	Орхонтуул	271	271	100
12	Түнхэл	271	180	66.4
13	Хүдэр	271	203	74.9
14	Хэрх	271	66	24.3
15	Шаамар	271	237	87.4
16	Жавхлант	271	158	58.3
17	Сант	271	214	79.0
18	Цагааннуур	271	244	90.0
19	Бугант	271	84	31.0
20	Рашаант	271	249	91.8
21	Нийт дүн	5420	4090	75.4

Хүснэгтээс харахад иргэдэд үйлчлэх зайлшгүй шаардлагатай эмийн төрлөөр Баянгол, Орхонтуул сумдын ЭМТ-ийн эмийн сангууд 100 хувь хангасан бол аймгийн дүнгээр сумдын эмийн санд байх зайлшгүй шаардлагатай эмийн 24.6 хувийг хангаагүй байна.

Тайлант онд Хэрх тосгоны ЭМТ-ийн эм баригч амаржсаны чөлөөтэй, Дулаанхаан тосгоны ЭМТ- нь мэргэжлийн эм баригчгүйгээс зөвхөн 11, 12 сард үйл ажиллагаа явуулсны улмаас цөөн нэр төрлийн эмээр үйлчилсэн байна.

Баянгол, Орхонтуул сумаас бусад сум, тосгодын ЭМТ-ийн эмийн сан нь иргэдэд үйлчлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрлөөр 24.3-98.9 хувиар хангасан байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 215 дугаар тушаалаар баталсан “Зайлшгүй шаардлагатай эмийн 7 дахь жагсаалт”-ыг зөрчсөн байна.

Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн 90 хувь нь ард иргэдийг зайлшгүй шаардлагатай эмийн төрлөөр ханган үйлчлэх, зорилго, зорилтоо бүрэн хэрэгжүүлээгүй гэж дүгнэж байна.

1.3. Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу.

Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаанд эрх бүхий албан тушаалтны зүгээс тавих дотоод хяналт туйлын хангалтгүй байна.

Тайлант онд сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаанд аймгийн ЭМГ-аас нэг удаа хяналт шалгалт хийсэн талаар дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд:

- Аймгийн ЭМГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь сумдын ЭМТ-үүдийн эмийн сангуудад “Эмийн санд тавих нийтлэг шаардлага” MNS 5260:2015 МУ-ын стандартын дагуу хяналт үнэлгээг хийсэн бөгөөд Баянгол, Бугант, Орхонтуул сумдын эмийн санг 92.5-95 хувиар “Маш сайн”, бусад сумдын эмийн сангуудыг 74.9-87.1 хувиар “Сайн” үнэлгээтэй дүгнэсэн,
- Хяналт шалгалтын явцад сумын ард иргэдээс ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагааг хэрхэн үнэлж байгаа талаар 8 асуулт бүхий санал асуулга авсан,
- Хяналт шалгалтаар нийтлэг 6 төрлийн зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийн хүрээнд цаашид авах арга хэмжээний чиглэл өгч ажилласан гэжээ.

Гэвч сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагааг ямар үзүүлэлтүүдээр хэрхэн үнэлсэн, тооцож гаргасан үнэлгээ болон санал асуулгыг нэгтгэж үр дүнг тодорхойлсон зэрэг нь аудитын явцад баримтаар нотлогдохгүй байна.

Аймгийн МХГ-аас Хушаат, Түшиг сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн бөгөөд Хушаат сумын эмийн санг 85 хувиар, Түшиг сумын эмийн санг 88 хувиар тус тус үнэлж, эрсдэл багатай гэж дүгнэсэн байна. Мөн Шаамар сумын ЭМТ-ийн үйл ажиллагааг хяналтын хуудсаар үнэлж шалгахад эмийн санг хамруулсан бөгөөд “Дунд” эрсдэлтэй гэж дүгнэсэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас Баруунбүрэн, Зүүнбүрэн, Орхон, Сант, Хүдэр, Цагааннуур сумдын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалтгалт хийсэн боловч ЭМТ-ийн эмийн сангуудыг хамруулаагүй байна.

Цагааннуур сум / ЭМТ-ийн эмийн сангийн орлогыг төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд өдөр тутам төвлөрүүлж байх зөвлөмж өгч ажилласан байна. / -аас бусад сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн зүгээс, Хушаат сумаас бусад ЭМТ-ийн төсвийн шууд захирагчийн зүгээс эмийн сангуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Өөрөөр хэлбэл, сумдын ЭЭС-г 2015 оны 11 дүгээр сард ЭМТ-ийн харьяалалд шилжүүлсэн атал төсвийн бүх шатны захирагчийн зүгээс эмийн сангуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

БҮЛЭГ 2

Сумдын ЭМТ-ийн эмийн сан нь орлогыг бүрэн төвлөрүүлж, холбогдох хууль журмын хүрээнд зарцуулж байна уу.

Зарим сумдын ЭМТ-нь эмийн сангийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд бүрэн төвлөрүүлэлгүй, төрийн сангийн хяналтгүйгээр кассаар зарцуулсан байна.

2.1. ЭМТ-үүд нь эмийн сангийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх.

СУЛ
ҮЙЛ

Зарим сумдын ЭМТ-үүд нь эмийн сангийн орлого, зарлагыг бүртгэлд бүрэн тусгаагүй байх эрсдэлтэй байна.

ЭА

Сумдын эмийн сангийн борлуулалтын орлогыг ЭМТ-ийн төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж ирсэн байна.

Тайлант онд сумдын ЭМТ-ийн эмийн сангууд нь нэмэлт санхүүжилтийн дансанд 353,545.7 мянган төгрөгийн, кассанд бэлнээр 25,826.7 мянган төгрөгийн зэрэг нийт 379,372.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 2

№	Сумд нэр	Төрийн сангийн НС-ийн дансанд төвлөрүүлсэн орлого /мян.төг/	ТСНС-ийн дансанд төвлөрүүлээгүй кассын орлого /мян.төг/	Тайлант оны нийт орлого /мян.төг/	Тайлант оны ашиг/ алдагдал /мян.төг/	Ашиг тооцсон хувь
1	Алтанбулаг	10,112.2		10,112.2	2,974.3	36.7
2	Баруунбүрэн	21,911.4	81.0	21,992.4	1,082.5	5.2
3	Зүүнбүрэн	11,575.8	668.5	12,244.3	2,549.9	26.4
4	Жавхлант	3,380.8	3,411.8	6,792.6	2,245.4	46
5	Орхон	30,969.9		30,969.9	5,246.0	20.4
6	Сант	22,998.8	11,675.0	34,673.8		
7	Номгон	28,622.5		28,622.5	4,110.2	16.8
8	Хушаат	32,296.4		32,296.4	7,499.0	30.2
9	Цагааннуур	8,343.9		8,343.9	3,844.0	53.1
10	Түшиг	14,719.1	2,178.8	16,897.9	3,826.3	29.3
11	Баянгол	52,462.5		52,462.5	8,708.8	16.6
12	Ерөө	16,047.8		16,047.8	2,448.3	15.2
13	Бугант	1,345.4	6,235.8	7,581.2	1,723.0	22.7
14	Шаамар	19,291.1		19,291.1	2,805.3	14.5
15	Дулаанхаан		582.8	582.8	172.4	29.5
16	Орхонтуул	18,605.4		18,605.4	3,073.7	16.5
17	Рашаант	21,027.4		21,027.4	2,997.0	14.2
18	Хүдэр	25,094.6	993.0	26,087.6	5,349.2	20.5
19	Түнхэл	13,548.6		13,548.6	1,931.1	14.2
20	Хэрх	1,192.1		1,192.1	231.8	19.4
	Нийт дүн	353,545.7	25,826.7	379,372.4	62,818.2	16,5

Хүснэгтээс харахад 2016 онд Сант сумын ЭМТ- нь худалдан авсан эмийн өртгийг нэмэгдүүлэхгүйгээр ард иргэдэд худалдан борлуулснаар ашиггүй тайлагнагдсан бөгөөд бусад эмийн сангууд /бүрэн үйл ажиллагаа явуулаагүй Дулаанхан, Хэрх тосгодоос бусад/ 1,082,5 - 8,708,8 мянган төгрөгийн ашигтай ажилласнаар аймгийн дүнгээр нийт орлогын 16,5 хувьтай тэнцэх 62,818.2 мянган төгрөгийн ашиг хуримтлуулжээ.

Баруунбүрэн, Зүүнбүрэн, Сант, Жавхлант, Түшиг сумд, Бугант, Дулаанхаан тосгодын ЭМТ-үүд нь эмийн сангийн нийт 25,826.7 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд бүрэн төвлөрүүлэлгүйгээр, кассаар авч зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 35.2⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

⁴ Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.
СУМДЫН ЭМТ-ИЙН ЭМИЙН САНГИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлант онд сумдын ЭМТ-ийн эмийн сангийн жижиглэн худалдаалах үнийг албан ёсоор тогтоолгүйгээр, 2015 онд аймгийн ЭМГ-ын дарга, эмийн сангийн эрхлэгчдийн хооронд байгуулсан гэрээнд тусгагдсан 30 хувийн нэмэгдэлтэй үнээр эмийн борлуулалт хийсэн байна.

Аудитын явцад тайлант оны борлуулалтын орлого, сум, тосгодын хүн амын тоо, үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангуудын тоог шалгуур үзүүлэлт болгон харьцуулж үзэхэд зарим сум, тосгодын ЭМТ-ийн эмийн сангууд харилцан адилгүй орлого төвлөрүүлсэн байна. Тухайлбал:

- Хүн амын тоо, суманд ажиллаж буй эмийн сангийн тооны хувьд адил Сант сумын эмийн сан- 34,673.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байхад Жавхлант сумын эмийн сан- 6,792.6 мянган төгрөгийн орлогыг,
- Хүн амын тоо, суманд ажиллаж буй эмийн сангийн тоо ойролцоо Түнхэл тосгоны эмийн сан- 13,548.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байхад Бугант тосгоны эмийн сан- 7,581.2 мянган төгрөгийн орлогыг,
- Хүн амын тоогоор хамгийн бага Рашаант тосгоны эмийн сан- 21,027.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байхад хүн амын тоогоор хамгийн өндөр Алтанбулаг сумын эмийн сан- 10,112.2 мянган төгрөгийн орлогыг,
- Суманд 4 эмийн сантай Баянгол сумын эмийн сан- 52,462.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байхад 3 эмийн сантай Цагааннуур сумын эмийн сан- 8,343.9 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Дээрхээс дүгнэхэд төсвөөс цалинжиж, ажиллах нөхцөлөөр нэгэн адил хангагдсан эм баригч нарын үйл ажиллагаанд нягтлан бодогчдын зүгээс бүртгэлээр тавих хяналт харилцан адилгүй байгаа нь зарим сумдын эмийн сангуудын / Жавхлант, Алтанбулаг, Цагааннуур сумд, Бугант тосгон / орлогыг бүртгэлд дутуу тусгасан байх эрсдэлийг үүсгэсэн байна.

Иймд орлого дутуу төвлөрүүлсэн байх эрсдэлтэй Алтанбулаг, Жавхлант, Цагааннуур сумд, Бугант тосгоны ЭМТ-ийн эм баригчдын үйл ажиллагаанд сумын ЭМТ-ийн болон Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогчдын зүгээс бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.2. Сумдын ЭМТ-үүд нь төвлөрүүлсэн эмийн орлогыг журмын дагуу зарцуулсан байна уу.

Зарим сумдын ЭМТ-үүд нь эмийн сангийн орлогыг төрийн сангийн хяналтаас гадуур, кассаар зарцуулсан байна.

Тайлант онд сумдын ЭМТ-ийн эмийн сан нь нийт зардлын 97.1 хувийг эмийн, 1.3 хувийг тавилга эд, хогшил худалдан авах, 0.4 хувийг тогтмол зардалд тус тус зарцуулж, оны эцэст 1.2 хувийг татан төвлөрүүлсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 3

№	Сумдын нэр	Тайлант оны нийт орлого /мян.төг/	Зардлын зарцуулалт /мян.төг/					
			Эм - дансаар	Эм - бэлнээр	Хөрөнгө, тавилга эд хогшил	Тогтмол зардал	Татан төвлөрүүл сэн дүн	Нийт зардлын дүн
1	Алтанбулаг	10,112.2	10,112.9					10,112.9
2	Баруунбүрэн	21,992.4	21,911.3			81.0		21,992.3
3	Зүүнбүрэн	12,244.3	11,575.8	583.9	84.6			12,244.3
4	Жавхлант	6,792.6	2,792.3	3,411.8	588.5			6,792.6
5	Орхон	30,969.9	30,433.2			537.5		30,970.7
6	Сант	34,673.8	22,998.8	11,675.0				34,673.8
7	Номгон	28,622.5	24,516.8		3,300.0		805.7	28,622.5
8	Хушаат	32,296.4	32,296.4					32,296.4
9	Цагааннуур	8,343.9	8,343.9					8,343.9
10	Түшиг	16,897.9	12,285.8	2,178.8			2,433.3	16,897.9
11	Баянгол	52,462.5	52,033.5		429.0			52,462.5
12	Ерөө	16,047.8	16,047.8					16,047.8
13	Бугант	7,581.2	1,345.4	6,235.8				7,581.2
14	Шаамар	19,291.1	18,578.7				712.4	19,291.1
15	Дулаанхаан	582.8		582.8				582.8
16	Орхонтуул	18,605.4	17,894.5			710.9		18,605.4
17	Рашаант	21,027.4	20,527.4		500.0			21,027.4
18	Хүдэр	26,087.6	24,593.6	993.0			501.0	26,087.6
19	Түнхэл	13,548.6	13,546.2				2.4	13,548.6
20	Хэрх	1,192.1	1,192.1					1,192.1
	Нийт дүн	379,372.4	343,026.4	25,661.1	4,902.1	1,329.4	4,454.8	379,373.8
	Нийт зардалд эзлэх хувь	100	90.4	6.7	1.3	0.4	1.2	100

Эрсдэлийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Ерөө сумын ЭМТ- 2,093.5 мянган төгрөгийн, Орхонтуул сумын ЭМТ- 2,388.6 мянган төгрөгийн, Түнхэл тосгоны ЭМТ- 1,575.2 мянган төгрөгийн зэрэг нийт **6,057.3** мянган төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13.1⁵ дэх заалтыг зөрчсөн байна.
- Зүүнбүрэн, Жавхлант, Сант, Түшиг, Хүдэр сумд, Бугант, Дулаанхаан тосгодын ЭМТ-үүд нь өөрийн орлогын нийт **25,826.7** мянган төгрөгийг төрийн сангийн хяналтгүйгээр, кассанд бэлнээр авч зарцуулсан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6⁶ дахь заалт заалтыг зөрчсөн байна.

⁵ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

⁶ Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кассатаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.

Дээрхээс дүгнэхэд зарим сумдын ЭМТ-д анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгадаг, эмийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэлгүйгээр төрийн сангийн хяналтаас гадуур, кассаар зарцуулдаг зөрчил оршиж байна.

2.3. Хөрөнгийг НББ-д үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэх.

Сумдын ЭМТ-үүдэд бүртгэл, санхүүгийн ихээхэн хэмжээний зөрчил оршиж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 105 дугаар тогтоолын дагуу ЭМГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь сумдын ЭЭС-гуудын 41,355.0 мянган төгрөгийн эргэлтийн, 35,755.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ЭМТ-үүдэд шилжүүлэн өгсөн байна.

Эрсдэлийн аудитаар бүртгэл, тайлагналтай холбоотой дараах алдаа, зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Бугант тосгоны ЭМТ- 5,858.2 мянган төгрөгийн, Жавхлант сумын ЭМТ- 6,204.1 мянган төгрөгийн, Сант сумын ЭМТ- 38,507.1 мянган төгрөгийн, Номгон тосгоны ЭМТ- 25,314.1 мянган төгрөгийн, Хэрх тосгоны ЭМТ- 1,192.1 мянган төгрөгийн, Шаамар сумын ЭМТ- 18,578.7 мянган төгрөгийн зэрэг нийт **95,654.3** мянган төгрөгийн эмийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21⁷ дэх заалтыг зөрчсөн,
- Эмийн сангийн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээс Шаамар сумын ЭМТ- 250.5 мянган төгрөгийн, Хүдэр сумын ЭМТ- 146.0 мянган төгрөгийн өр төлбөр, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч бүртгэл тайланд огт тусгаагүйгээс Сант сумын ЭМТ- 3,833.2 мянган төгрөгийн өр төлбөр, Түшиг сумын ЭМТ-ийн эм баригч Д.Гүндэгсүрэн нь эмийн орлогыг дутуу төвлөрүүлж, шамшигдуулсан 2,178.8 мянган төгрөгийн, Хүдэр сумын ЭМТ-нь Моносфарм ХХК-д илүү шилжүүлсэн 324.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 14.4.2, 14.4.3⁸ дахь заалтуудыг зөрчсөн,
- Баруунбүрэн сумын ЭМТ- нь эмийн сангийн 2,973.3 мянган төгрөгийн эмийн эхний үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 14.4.2⁹ дахь заалтыг зөрчсөн,
- Ерөө, Жавхлант сумдын ЭМТ-үүд нь жилийн эцэст эмийн сангийн хөрөнгийн тооллого хийгээгүй, Шаамар сумын ЭМТ- нь тооллогын бүртгэлийг комиссын гишүүдийн гарын үсгээр баталгаажуулаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 12.2¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна.

⁷ Бараа материалыг худалдан авсан үед:

ДТ.Бараа материал

Кт.Мөнгөн хөрөнгө/Дансны өглөг

⁸ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, 14.4.3. бүх өр төлбөр

⁹ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

¹⁰ Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө

СУМДЫН ЭМТ-ИЙН ЭМИЙН САНГИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН

СЭА-2017/02/СТА-ЭА

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлант онд Зүүнбүрэн, Жавхлант сумд, Номгон тосгоны ЭМТ-үүд нь эмийн сангийн орлогоос нийт 3,973.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материал худалдан авч бүртгэл, тайланд тусгасан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүйгээс ихээхэн хэмжээний санхүүгийн зөрчил оршиж байна.

1. Зарим сумдын ЭМТ-үүд нь эмийн сангийн тусгай зөвшөөрлийг сунгуулалгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.
2. Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн 90 хувь нь ард иргэдийг зайлшгүй шаардлагатай эмийн төрлөөр ханган үйлчлэх, зорилго, зорилтоо бүрэн хэрэгжүүлээгүй байна.
3. Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаанд бүх шатны төсвийн захирагчийн зүгээс тавих дотоод хяналт туйлын хангалтгүй байна.
4. Зарим сумдын ЭМТ- нь эмийн сангийн орлого, зарлагыг бүртгэлд бүрэн тусгаагүй байх эрсдэлтэй байна.
5. Зарим сумдын ЭМТ- нь эмийн сангийн орлогыг төрийн сангийн хяналтаас гадуур, кассаар зарцуулсан байна.
6. Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний зөрчил оршиж байна.
7. Сумдын ЭМТ- нь эмийн сангийн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
8. Зарим сумдын ЭМТ- нь эмийн тайланг зохих журмын дагуу гаргаж хэвшээгүй байна.

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Эрсдэлийн аудитаар дараах зөрчлүүдэд төлбөрийн акт, зөрчил арилгах албан шаардлага бичигдлээ. Үүнд:

Нэг. Төлбөрийн акт:

- ❖ Түшиг сумын ЭМТ-ийн эм баригч Д.Гүндэгсүрэн нь эмийн орлогыг дутуу төвлөрүүлж, шамшигдуулсан 2,178.8 мянган төгрөгийн, Хүдэр сумын ЭМТ-нь Моносфарм ХХК-д илүү шилжүүлсэн 324.8 мянган төгрөгийн зэрэг нийт **2,503.6** мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй зөрчилд авлагыг барагдуулах төлбөрийн акт бичигдлээ.

Хоёр. Албан шаардлага:

- ❖ Эмийн сангийн эмийн тайлан, мэдээг тухай бүр гаргаж хэвшээгүй, үйл ажиллагаанд хяналт тавиагүйгээс аудитын явцад хүндрэл учруулсан Ерөө, Хүдэр, Шаамар сумд, Бугант тосгон, сүүлийн хагас жилийн санхүүгийн баримтыг аудитад хамруулаагүй Түшиг сумын ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч

нарт сахилгын шийтгэл ногдуулж, холбогдох тушаал, шийдвэрийг Төрийн аудитын газарт ирүүлэх.

- ❖ Эмийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд бүрэн төвлөрүүлэлгүй кассаар авч, төрийн сангийн хяналтаас гадуур зарцуулсан Баруунбүрэн сумын ЭМТ- 81.0 мянган төгрөгийн, Зүүнбүрэн сумын ЭМТ- 668.5, Сант сумын ЭМТ- 11,675.0 мянган төгрөгийн, Жавхлант сумын ЭМТ- 3,411.8 мянган төгрөгийн, Бугант тосгоны ЭМТ- 6,235.8 мянган төгрөгийн, Дулаанхаан тосгоны ЭМТ- 582.8 мянган төгрөгийн, Түшиг сумын ЭМТ- 2,178.8 мянган төгрөгийн, Хүдэр сумын ЭМТ- 993.0 мянган төгрөгийн зэрэг нийт **25,826.7** мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох,
- ❖ Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан Ерөө сумын ЭМТ- 2,093.5 мянган төгрөгийн, Орхонтуул сумын ЭМТ-2,388.6 мянган төгрөгийн, Түнхэл тосгоны ЭМТ- 1,575.2 мянган төгрөгийн зэрэг нийт **6,057.3** мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, холбогдох баримтыг нөхөн бүрдүүлэх,
- ❖ Эмийг тооцооны дансаар дамжуулалгүй, шууд зардлаар тайлагнасан Бугант тосгоны ЭМТ- 5,858.2 мянган төгрөгийн, Жавхлант сумын ЭМТ- 6,204.1 мянган төгрөгийн, Сант сумын ЭМТ- 38,507.1 мянган төгрөгийн, Номгон тосгоны ЭМТ- 25,314.1 мянган төгрөгийн, Хэрх тосгоны ЭМТ- 1,192.1 мянган төгрөгийн төгрөгийн, Шаамар сумын ЭМТ- 18,578.7 мянган төгрөгийн зэрэг нийт **95,654.3** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх,
- ❖ Жилийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээс Сант сумын ЭМТ- 3,833.2 мянган төгрөгийн, Шаамар сумын ЭМТ- 250.5 мянган төгрөгийн, Хүдэр сумын ЭМТ- 146.0 мянган төгрөгийн зэрэг нийт **4,229.7** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчлийг давтан гаргахгүй байх,
- ❖ Баруунбүрэн сумын ЭМТ- нь эмийн сангийн **2,973.3** мянган төгрөгийн эмийн эхний үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх,
- ❖ Ерөө, Жавхлант сумдын ЭМТ-үүд жилийн эцэст эмийн сангийн хөрөнгийн тооллого хийгээгүй, Шаамар сумын ЭМТ- нь тооллогын бүртгэлийг комиссын гишүүдийн гарын үсгээр баталгаажуулаагүй зэрэг нийт **134,741.3** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага бичигдлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга Ш.Оргил-д:

- Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх.

Аймгийн ЭМГ-ын дарга Ж.Од-д:

- Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
- Сумдын ЭМТ-ийн эмийн сангийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зохих хууль журмын дагуу сунгах арга хэмжээ авах.

Сумдын Засаг дарга нарт:

- Сумдын ЭМТ-ийн дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд эмийн сангийн үйл ажиллагааг тусгаж, дүгнэлт өгч хэвших.
- ЭМТ болон иргэдэд худалдаалах эмийн жижиглэнгийн үнийг албан ёсоор тогтоож өгөх.
- Эмийн сангийн эмийн орлого, зарлагыг бүртгэлд бүрэн тусгаж байгаа эсэхэд хяналт тавьж, тайлан дүнг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
(Алтанбулаг, Жюхлант, Цагааннуур сумд, Бугант тосгон)

Сумдын ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч нарт:

- Эмийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах
- Эмийн сангийн эм баригч нартай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулж, биелэлтийг тооцож ажиллах.
- Аод иргэдийг зайлшгүй шаардлагатай эмийн төрлөөр хангах үйлчилгээг хатуу саалтад заасан хэмжээнд хүргэх.
- Эмийн сангийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд журмын дагуу бүрэн төвлөрүүлэх.
- Анхан шатны баримтын бүрдлийг хангаж, эмийн тайланг журмын дагуу гаргаж хэвшүүлэх.
- Эмийн сангийн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэх.
- Эмийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд НББ-ээр тавих хяналтыг сайжруулах.

Сумдын ЭМТ-ийн эм баригч нарт:

- Эмийн сангийн өдөр тутмын орлогыг төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд бүрэн төвлөрүүлэх.
- Эмийн тайланг үнэн зөв гаргах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.
- Эмийн сангийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааны мэдээ, тайланг сар бүр гаргаж, мэдээллийн самбараар ил тод мэдээлж байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХ.ТАХ АУДИТОР

С.БААСАНСҮРЭН

АУДИТОР

Ц.УРТНАСАН

**Сумдын ЭМТ-ийн эм баригч нарыг ажилд томилсон тушаал,
2016 онд олгосон цалингийн судалгаа**

Хавсралт №1

№	Сумдын нэр	Эм баригч нарын нэрс	ЭМТ-ийн бүтцэд авсан тушаалын огноо, дугаар	Цалингийн шатлал	Сарын цалин /мян.төг/	Нийт цалин /мян.төг/
1	Алтанбулаг	Л.Цогзолмаа	2016.01.04 №05	ТҮЭМ-3-2	518.5	7,063.5
2	Хушаат	М.Отгон	2016.01.07 №01	ТҮЭМ-3-4	558.9	9,120.7
3	Сант	А.Оюун-Эрдэнэ М.Мөнхшүр	2015.12.26 Б/03, 2016.07.22 Б/44	ТҮЭМ-3-1	518.5	7,677.1
4	Орхон	Ц.Мөнхзул	2015.12.21 Б/61	ТҮЭМ-3-5	587.9	9,211.3
5	Номгон	П.Амаржаргал	2016.01.02 №02	ТҮЭМ-3-3	558.9	8,396.2
6	Цагааннуур	Э.Энхтуяа	2016.01.02 Б/02	ТҮЭМ-3-5	558.9	9,304.9
7	Зүүнбүрэн	Т.Чимгээ	2016.01.04 Б/04	ТҮЭМ-3-5	587.9	8,527.2
8	Жавхлант	Д.Мядагмаа	2016.01.08 А/02 2016.08.01 Б/19	ТҮЭМ-2-4	501.4	5,349.9
9	Баруунбүрэн	Б.Сайнтөмөр	2016.01.07 Б/03	ТҮЭМ-3-5	587.9	9,311.7
10	Түшиг	Д.Гүндэгсүрэн	2016.01.06 Б/01	ТҮЭМ-3-5	587.9	8,676.8
11	Баянгол	Г.Отгонцэцэг	2016.09.15 Б/82	ТҮЭМ-3-5	587.9	5,660.1
12	Ерөө	Г.Сүхцэцэг	2016.01.06 Б/01	ТҮЭМ-1-1	434.6	5,383.3
13	Бугант	С.Болормаа	2016.01.27 №06	ТҮЭМ-3-1	466.5	5,497.1
14	Шаамар	Ж.Сэлэнгэ	2016.01.01 №01	ТҮЭМ-4-4	552.7	6,632.4
15	Дулаанхаан	О.Хандсүрэн	2016.10.04 Б/17	ТҮЭМ-3-1	518.5	1,938.9
16	Орхонтуул	Ж.Мягмаржав	2015.12.25 №50	ТҮЭМ-2-4	469.8	6,156.3
17	Рашаант	Ц.Түмэндэмбэрэл	2016.01.04 Б/04	ТҮЭМ-3-5	587.9	7,674.9
18	Хүдэр	Ш.Батчимэг	2016.01.04 Б/02	ТҮЭМ-3-1	518.5	6,222.0
19	Түнхэл	Г.Энхмаа	2016.01.20 Б/04	ТҮЭМ-3-1	518.5	6,222.0
20	Хэрх	Н.Отгонжаргал	2016.11.01 5/51	ТҮЭМ-3-1	518.5	1,037.0
		Нийт дүн				128841.3

Сумдын ЭМТ-ийн эм баригч нарыг ажилд томилсон тушаал,
2016 онд олгосон цалингийн судалгаа

Хаясралт №1

№	Сумдын нэр	Эм баригч нарын нэрс	ЭМТ-ийн бүтээгдээсний тушаалын огноо, дугаар	Цалингийн шатлал	Баруун цалин мян.төг	Нийт цалин мян.төг
1	Алтанбулаг	Л.Цогзолмаа	2016.01.24 №05	ТҮЭМ-3-2	518.5	7,033.5
2	Хушаат	М.Отгон	2016.01.07 №01	ТҮЭМ-3-4	558.9	9,120.7
3	Сант	А.Оюун-Эрдэнэ М.Мөнхшүр	2016.12.28 Б/03, 2016.07.22 Б/44	ТҮЭМ-3-1	518.5	7,677.1
4	Орхон	Ц.Мөнхзул	2016.12.21 Б/61	ТҮЭМ-3-5	567.9	9,211.3
5	Номгон	П.Амаржаргал	2016.01.02 №02	ТҮЭМ-3-3	558.9	8,396.2
6	Цагааннуур	Э.Энхтуяа	2016.01.02 Б/02	ТҮЭМ-3-5	558.9	9,304.9
7	Зүүнбүрэн	Т.Чимгээ	2016.01.04 Б/04 2016.01.08 А/02	ТҮЭМ-3-5	567.9	8,527.2
8	Жавхлант	Д.Мядагмаа	2016.08.01 Б/19	ТҮЭМ-2-4	501.4	5,349.9
9	Баруунбүрэн	Б.Сайнтөмөр	2016.01.07 Б/03	ТҮЭМ-3-5	567.9	9,311.7
10	Түшиг	Д.Гүндэгсүрэн	2016.01.06 Б/01	ТҮЭМ-3-5	567.9	9,678.8
11	Баянгол	Г.Отгонцэцэг	2016.05.15 Б/82	ТҮЭМ-3-5	567.9	5,660.1
12	Ерөө	Г.Сүхцэцэг	2016.01.06 Б/01	ТҮЭМ-1-1	404.8	5,383.3
13	Бугант	С.Болормаа	2016.01.27 №05	ТҮЭМ-3-1	466.5	5,497.1
14	Шээмэр	Ж.Сэлэнгэ	2016.01.01 №01	ТҮЭМ-4-4	552.7	6,632.4
15	Дулаанхаан	О.Хандсүрэн	2016.10.04 Б/17	ТҮЭМ-3-1	518.5	1,938.9
16	Орхонтуул	Ж.Мягмаржав	2016.12.25 №50	ТҮЭМ-2-4	469.8	6,153.3
17	Рашаант	Ц.Түмэндэмбэрэл	2016.01.04 Б/04	ТҮЭМ-3-5	567.9	7,674.0
18	Хүдэр	Ш.Батчимэг	2016.01.04 Б/02	ТҮЭМ-3-1	518.5	6,222.0
19	Түнхэл	Г.Энхмаа	2016.01.20 Б/04	ТҮЭМ-3-1	518.5	6,222.0
20	Хэрх	Н.Отгонжаргал	2016.11.01 Б/51	ТҮЭМ-3-1	518.5	1,037.0
Нийт дүн						128841.3

ЭМТ-ийн ЭГЭЭЛТИЙН САНГИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА

СЭА-2017/02/СТА-ЭА